

**No prohibited knives at school****Эцэг эх, асран хамгаалагч болон сурагчдад зориулсан мэдээлэл**  
**Сургууль дээр хутга авчрахыг хориглох тухай**

NSW нь Австрали улсын хутганы тухай хамгийн хатуу хуультай муж юм. Сурагчид олон нийтийн газар эсвэл сургууль дээр хориотой хутга авч явах нь хуулиар хориотой. Буруутай этгээдэд \$4,400-н торгууль оноох, 4 жил хорих, эсвэл уг хоёр ялыг зэрэг оноох боломжтой. Торгуулийн дээд хэмжээ нь \$11,000 байдаг.

**Ямар ч нөхцөлд сургууль дээр хутга авчрахыг хориглосон болно.**

Сургуулиуд бүх сурагчдын аюулгүй байдлыг хангах бодлогыг баримталдаг тул ямар ч төрлийн хориотой хутгыг сургууль дээр авчрахыг зөвшөөрөхгүй. Үүнд, эвхдэг хутга, хуйтай хутга, чинжаал хутга, тренч хутга, эрвээхэй хутга болон шиддэг од эсвэл зэвсэг болгон ашиглаж болох ямар ч төрлийн эд зүйлс (сийлүүр гэх мэт) орно.

Хэрвээ сурагч сургууль дээр хутга эзэмшиж явсан эсвэл хутга авчирсан бол сургуулийн захирал цагдаад мэдэгдэх болно. Тухайн сурагчийг тэр даруй сургуулиас албадан гаргах эсвэл сургуулиас хасах арга хэмжээг сургуулийн зүгээс нэн даруй авах боломжтой.

Хэдийгээр сурагч нь уг хутгыг ашигладаггүй эсвэл хэн нэгэнд халдах зорилгогүй байсан ч сурагчийн цүнх эсвэл хувцасны шүүгээнд нь хутга байвал тухайн сурагчийг хутга эзэмшигч гэж тооцно. Өөрийгөө хамгаалах зорилгоор хутга авч явах нь мөн хууль бус. Бусдын сайн сайхан, аюулгүй байдал алдахуйц аливаа асуудал гарвал үүнийг сургуулийн захиралд мэдэгдвэл зохино.

Сурагчийн өдрийн хоолны саванд нь түрхлэгний эсвэл жимсний хутга хийхгүй байх, мөн эсвэл гар урлалын зориулалтын хутган хэрэгслийг өгч явуулахгүй байхыг эцэг эхчүүд болон асран хамгаалагчдад зөвлөж байна. Хутга ашиглах шаардлагатай хичээлд, тухайлбал хоолны эсвэл гар урлалын хичээлүүд дээр ангийн багш нь шаардлагатай хэрэгслээр ханган хяналт тавих болно.

Сурагч бүр өөрсдийгөө сургууль дээр аюулгүй бөгөөд хамгаалагдсан орчинд байгаагаар мэдрэх эрхтэй. Сурагч сургууль дээр хутга авчрах чухал шалтгаан гэж хэзээ ч байхгүй.

Зарим ахлах ангид ордог зочлох үйлчилгээний (hospitality) хичээлд хүүхдүүд өөрсдийн хутгатай байхыг шаарддаг байж магадгүй юм. Сургуулийн зүгээс эдгээр хичээлүүдийн талаар болон хутгыг хэрхэн гэрээс сургуулийн хооронд хууль ёсоор биедээ авч явах зааварчилгааг эцэг эхчүүд, асран хамгаалагчид болон сурагчдад олгох болно.

**Илүү хатуу шийтгэл оноогдоно**

Энэ хууль эцэг эхчүүд болон асран хамгаалагчдад хариуцлага хүлээлгэж байна. Эцэг эхчүүд болон асран хамгаалагчид хүүхдэдээ сургуулийн дүрэм, журам болон хутганы тухай тус мужийн хуулийг сайн тайлбарлаж ойлгуулах ёстой.

Эцэг эхчүүд болон асран хамгаалагчид эдгээр хуулиудыг мэдэж байх хэрэгтэй ба учир нь хэрвээ тэд хүүхдэдээ хутга авч явахыг нь зөвшөөрвөл тэд өөрсдөө мөн хариуцлага хүлээх болно.

Хутга авч явсан байх сэжиг бүхий ямар ч хүүхдийг цагдаа нэгжиж болох ба нэгжлэгийн үеэр олдсон аливаа аюултай эд зүйлсийг хурааж авна. Тухайн хүүхэд цагдаагийн нэгжлэг хийх шаардлагыг биелүүлэх ёстой ба хэрвээ эсэргүүцвэл баривчлагдан хариуцлага хүлээх болно.

Хутгатай холбоотой халдлага эсвэл сүрдүүлэг нь маш хүнд хорих ялтай ба сурагч зодоонд оролцон хэн нэгнийг хутгаар шархдуулах гэх мэт үйлдэл үүнд хамаарна.

Хэрвээ сурагч энэ төрлийн гэмт хэрэгт бусад залуу хүмүүстэй хамтран үйлдвэл хорих ял нь илүү хүндрэх болно. Зарим тохиолдолд 14-25 жил хүртэлх хорих ял авч магадгүй юм.

Мөн 16-аас доош насны хүүхдэд хутга зарах нь хууль бус үйлдэл юм.



---

## Чөлөөлөлт

Зарим тохиолдолд хутга зайлшгүй биедээ авч явах шаардлагатай бөгөөд тухайн хүн уг хутгыг эзэмших “хүндэтгэн үзэх шалтгаан”-ыг нотлох боломжтой нөхцөл байдал байж болно.

“Хүндэтгэн үзэх шалтгаан” гэдэгт дараах нөхцөл байдлын улмаас хутга авч явах “зайлшгүй шалтгаанууд” орно:

- Тодорхой мэргэжил, боловсрол эзэмших эсвэл сургалтанд хуулийн дагуу хамрагдахын тулд
- Хуулиар зөвшөөрөгдсөн үзвэр үйлчилгээ, амралт зугаалга эсвэл спортын арга хэмжээнд оролцох
- Зөвхөн шашны зорилгоор, эсвэл
- Дээр дурдсан газруудад очих эсвэл буцах аялалын үеэр.

### Утсан орчуулгын үйлчилгээ

Та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн захиралтай утсаар холбогдоорой. Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээ болох 131 450 руу залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй.

Операторт холбогдохыг хүссэн дугаараа хэлэх ба оператор тухайн шугамд таны яриаг орчуулах орчуулагчийг холбох болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.